



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/182

Булган сум

**Мал, амьтны шилжилт хөдөлгөөний
талаар авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4, 7 дугаар зүйлийн 7.4, 7.5, 7.6 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай” 225 дугаар тогтоол, 2019 оны “Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журам батлах тухай” 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээний хүрээнд мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах, өвчин гарах эрсдэлээс сэргийлэх зорилгоор 2026 оны 03 дугаар сарын 09-ны өдрөөс 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд отор нүүдэл, үржлийн зориулалтаар аймгийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэхэд мал эмнэлгийн цахим гэрчилгээтэй, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт болон шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан, хавсралтад заасан өвчний лабораторийн шинжилгээ хийгдсэн эсэхийг хянан шалгаж, нэвтрүүлэхийг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн), Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Отор нүүдэл, үржлийн зорилгоор шилжилт хөдөлгөөн хийх мал, амьтны төрөл, тоо, отор, нүүдэл хийх чиглэл, хугацаа зэрэг судалгааг авах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналтыг тавих, мал, амьтны гоц халдварт өвчин, халдварт өвчний талаарх мэдээлэл, сэрэмжлүүлгийг иргэд, малчдад хүргэж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч (О.Ундрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010237

Аймгийн Засаг даргын 2026 оны
дугаар сарын 10-ны/ний өдрийн
дугаар захирамжийн хавсралт

МАЛ, АМЬТНЫ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН ХИЙХЭД ШИНЖИЛГЭЭНД
ХАМРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ӨВЧНИЙ ЖАГСААЛТ

1.Халдварт өвчин:

- Адууны халдварт цус багадах өвчин
- Адууны ям
- Нийлүүлгийн өвчин
- Томуу

2.Гоц халдварт өвчин

- Үхрийн арьс товруутах
- Шүлхий
- Хонь, ямааны цэцэг
- Бог малын мялзан
- Гахайн мялзан

--o00o--